**"УЛААНБААТАР ТЕАТР" ОНӨТҮГ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 03 өдөр Дугаар А/16 Улаанбаатар хот

Албан хаагчдад олгох цалинг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дах заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 5, 6 дугаар хавсралт, 2023 оны 241 дүгээр тогтоолын 9, 10 дугаар хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан театрын албан хаагчдад олгох үндсэн цалин, ур чадварын нэмэгдэл олгох хувийг шинэчлэн, хавсралтаар баталсугай.

2.Шинэчлэн баталсан цалингийн хэмжээг Хүний нөөцийн нэгдсэн санд бүртгэж, цалин олголтын үйл ажиллагааны хэвийн горимыг хангаж ажиллахыг Хүний нөөцийн менежер (Л.Одгэрэл)-т үүрэг болгосугай.

3.Хавсралтаар баталсан албан хаагчдын цалинг зохих журмын дагуу бодож, сар бүр тооцон олгохыг Нягтлан бодогч (С.Эрдэнэцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны ахлах мэргэжилтэн (Б.Түмэндэлгэр)-д үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ТЕАТР

ДАРГА Ю.ГЭРЭЛБААТАР

УЛААНБААТАР ХОТ

D:/2023/secretary/dargiin tushaal /A4/

314530003